



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны горимд
зарим өөрчлөлт оруулах тухай

Сүүлийн 2 жилийн хугацаанд үнэт цаасны зах зээлийн арилжааны хэмжээ, хөрвөх чадвар хангалтгүй байгааг ТЭМДЭГЛЭН, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны арилжааг идэвхижүүлэх, түүний хөрвөх чадварыг сайжруулах суурь нөхцлийг бүрдүүлэх зорилгоор үнэт цаасны төлбөр, тооцооны бие даасан дэд бүтцийг бий болгож төлбөрийн гүйцэтгэл баталгаажих, кастодианы үйл ажиллагаа зах зээлд бүрэн нэвтрэх хүртэлх хугацаанд үнэт цаасны төлбөр, тооцоог 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн Хөрөнгийн бирж дээр арилжаа хийгдсэн өдрөөс хойш дараагийн ажлын өдөрт /Т+1/ багтаан гүйцэтгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны эрсдлийг үүсгэхгүй байх, түүний гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор арилжааны банкин дахь харилцагчдын үнэт цаас худалдах, худалдан авах тусгай дансанд үнэт цаасны төлбөрийг 100 хувь урьдчилан байршуулсны дараа тэдгээрийн захиалгыг Хөрөнгийн биржийн арилжааны системд оруулж байхыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүн нийт брокер, дилерийн компаниудад үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан “ҮЦТТТХТ” ХХК-иас баталсан “Үнэт цаасны төлбөр тооцоог Т+3 системээр гүйцэтгэх түр журам”, “Төлбөрийн баталгааны сангийн журам” болон холбогдох бусад үйл ажиллагааны дотоод журам, заавар, гэрээ, маягтад 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн дотор зохих өөрчлөлтийг оруулах, шинэчлэн найруулах, шаардлагатай тохиолдолд хүчингүй болгож ажиллахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д даалгасугай.

4. Үнэт цаасны арилжааны төлбөр гүйцэтгэх үйл ажиллагаатай холбоотойгоор харилцагчийн данснаас зөвхөн харилцагч брокерын компанийн зөвшөөрлийн үндсэн дээр зарлагын гүйлгээг гүйцэтгэх, брокер, дилерийн компани нь үнэт цаасны төлбөр гүйцэтгэх нэгээс дээш тооны банкиг чөлөөтэй сонгох нөхцлийг хангаж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦТТТХТ” ХХК болон Төлбөр гүйцэтгэх банкуудад тус тус үүрэг болгосугай.

5. Харилцагч худалдан авах үнэт цаасны төлбөрийг 100 хувь урьдчилан байршуулж, үнэт цаасны арилжаанд оролцох болсонтой холбогдуулан Төлбөрийн баталгааны сан болон холбогдох барьцаа хөрөнгийн санд мөнгөн хөрөнгө байршуулах шаардлагагүй бөгөөд түүнд байгаа мөнгөн

000616

хөрөнгийг чөлөөлөхийг “ҮЦГТТХТ” ХХК /Т.Гандулам/, Төлбөр гүйцэтгэх банкуудад тус тус даалгасугай.

6. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Төлбөр тооцооны шинэ горимд шилжих бэлтгэл ажлын хүрээнд авах арга хэмжээний тухай” 118 дугаар тогтоолыг 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

7. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА